


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

02.03 - 02.07



Зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагууд болох Moody's, Fitch болон Standard & Poors агентлагууд 2020 онд Монгол улсын зээлжих зэрэглэлийг хэрхэн дүгнэснийг шинжээчийн булангаар хүргэж байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт эдийн засгийн сүүлийн үеийн үзүүлэлтүүд эерэг байгаа болон БНХАУ-аас эхтэй коронавирусын тархалтыг дэлхийн эдийн засаг хохирол багатай даван гарна гэсэн хүлээлтээс үүдэн АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа.

Зах зээлийн үнэлгээ өндөртэй индексүүд болон технологийн компаниудыг түлхүү агуулдаг Nasdaq индекс түүхэн дээд хэмжээндээ хүрсэн бол S&P 500 индекс 6-р сараас хойших долоо хоногийн хамгийн их өсөлтийг үзүүлээ.

S&P 500 индексийн сагсанд багтах Microsoft компанийн хувьцааны ханш өссөнтэй холбоотой мэдээлэл технологийн салбар хамгийн их өсөлттэй байлаа. Мөн энэ долоо хоногт Tesla компани зай хураагуурын технологид ахиц гаргасантай холбоотой хувьцаа нь өсөлт үзүүлсэн ба Twitter компанийн орлого шинжээчдийн таамаглаж байсан хэмжээнээс их байснаас үүдэн хувьцааны үнэ өссөн байна. Хүүний төвшинд мэдрэг ус, цахилгаан, дулааны салбарын компаниудын хувьцааны ханш урт хугацаат ЗГҮЦ-ны өгөөж нэмэгдсэнтэй холбоотойгоор уналттай байлаа.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд дээд ханшиндаа хүрч хаагдлаа. Энэхүү өсөлт нь компаниудын санхүүгийн үзүүлэлтүүд сайн байсантай болон БНХАУ-аас коронавирусын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор АНУ-аас импортоор орж ирдэг зарим нэг бараа бүтээгдэхүүнүүдийн гаалийн татварыг бууруулсантай холбоотой.

Европын Төв Банкны (ЕТБ) Ерөнхийлөгч хатагтай Кристин Лагард Европын холбооны Парламентад Евро бүсийн эдийн засгийн өсөлт тогтмол байгаа ба мөнгөний хэт зөөлөн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй хэвээр байгаа гэж мэдэгджээ. Мөн тэрээр, хувийн хэрэглээний хэмжээ их, ажилгүйдлийн төвшин бага байгаатай холбоотой эдийн засаг өсөлттэй байгаа ч гадаад хүчин зүйлс бүс нутгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгааг онцолжээ.

Япон: Энэ долоо хоногт Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлт үзүүлж өнгөрөгч долоо хоногийн алдагдлаа нөхлөө.

Японы Төв Банк (ЯТБ) -ны орлогч дарга ноён Масазуми Вакатабе, Эхимэ мужийн бизнес эрхлэгчдэд тавьсан илтгэлдээ, хэрэв үнийн тогтвортой байдалд хүрэх явцад удаашрал үүсвэл төв банкнаас мөнгөний бодлогыг дахин сулруулна хэмээн мэдэгджээ. Мөн тэрээр, үйлдвэрлэлийн болон үйлдвэрлэлийн бус салбарын гүйцэтгэлийн хамаарал эсрэг болсон нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны маргаанаас үүссэн дэлхийн эдийн засгийн удаашралтай холбоотой хэмээн тайлбарлажээ.

БНХАУ: БНХАУ-ын хөрөнгийн зах зээл 1-р сарын 23-аас Цагаан сарын баяртай холбоотой хаалттай байсан бол энэ долоо хоногийн Даваа гарагт буюу 2-р сарын 3-ны өдөр нээгдлээ. Урт амралтын дараагаар Даваа гарагт хувьцааны ханшууд Уханий коронавирусын тархалттай холбоотой огцом уналт үзүүлсэн байна. Гэхдээ, Баасан гараг гэхэд уналтын ихэнх хэсгийг нөхсөн нь Уханий коронавирусын шинээр халдвар авагчдын тоо 2 өдөр дараалан буурсантай холбоотой байлаа.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,738.33	-0.48% ▼
Dow Jones	АНУ	29,102.51	3.00% ▲
S&P 500	АНУ	3,327.71	3.17% ▲
Nasdaq	АНУ	9,520.51	4.04% ▲
S&P/TSX	Канад	17,655.49	1.95% ▲
FTSE 100	Их Британи	7,466.70	2.48% ▲
S&P/ASX 200	Австрали	7,022.60	0.08% ▲
Nikkei 225	Япон	23,827.98	2.68% ▲
Hang Seng	Хонг Конг	27,404.27	4.15% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	114.32
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.63
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.48
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	108.16
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	103.26
DBM' 2023	USD	7.250%	107.00
TDBM' 2020	USD	9.375%	101.48
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.66

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.665	0.00 ▲
Libor 3M	1.731	-0.02 ▼
Libor 6M	1.740	0.00 ▼
Libor 1YR	1.835	0.03 ▲
US 2YR Bond	1.387	0.05 ▲
US 3YR Bond	1.372	0.06 ▲
US 5YR Bond	1.386	0.05 ▲
US 10YR Bond	1.565	0.04 ▲

Валютын ханш	2020.02.07	Өөрчлөлт
USD	2,753.93	0.09% ▲
CNY	394.31	-0.59% ▼
EUR	3,019.96	-0.48% ▼
RUB	43.29	-0.73% ▼
KRW	2.32	0.43% ▲
JPY	25.06	-0.67% ▼
CAD	2,069.85	-0.59% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,570.44	-1.18% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	17.70	-1.89% ▼
Зэс	USD/lb.	255.30	1.43% ▲
Нүүрс	USD/MT	70.25	4.59% ▲
WTI газрын тос	USD/bbl.	50.32	-2.40% ▼
Brent газрын тос	USD/bbl.	54.47	-6.34% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. XII	5.2%
Бодлогын хүү	2019. XII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. XII	11.02%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	11.29%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. XII	4.75%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. XII	16.84%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. XII	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 55 компанийн 951.5 сая төгрөгийн 17,805,317 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол даатгал” /CHE/ компанийн хувьцаа 101.12%-аар буюу хамгийн ихээр өсөж 430.56 төгрөг хүрч хаагдсан бол “Хай би ойл” /HBO/ компанийн хувьцаа 16.29%-аар буурч 58.60 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

02-р сарын 07-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,674.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,738.33 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.48%-аар буурсан байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)
Арилжигдсан үнийн дүн	951.5
Зах зээлийн үнэлгээ	2,674,213.4

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,738.33	-0.48% ▼
MSE I индекс	9,336.25	0.04% ▲
MSE II индекс	7,844.36	0.98% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Хай би ойл	16,610,016	768,997,846
АПУ	54,902	33,769,941
Монгол базальт	131,953	32,707,224
Мандал даатгал	617,071	30,718,644
Говь	70,345	18,156,243

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол даатгал	430.56	101.12% ▲
Монинжбар	130.00	18.18% ▲
Монголын цахилгаан холбоо	472.00	17.96% ▲
Дархан нэхий	13,810.00	14.99% ▲
Шарын гол	1,255.00	14.09% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Хай би ойл	58.60	-16.29% ▼
Блюскай секьюритиз	1,700.00	-15.00% ▼
Сор	977.50	-15.00% ▼
Стандарт ноос	240.00	-14.29% ▼
Стандарт проперти групп	57.00	-13.64% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ард Капитал	1,540,233,589
Би Ди Сек	63,575,142
Голомт Капитал	44,789,649
Блүмсбюри Секюритиес	44,022,184
Ти Ди Би Капитал	34,998,823

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	614.31	655,737
Таван толгой	6,495.00	342,060
МИК Холдинг	14,940.00	309,397
Говь	255.00	198,929
Инвескор ББСБ	2,582.00	185,201

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

СЗХ-ны 2020 оны 1-р сарын 29-ний өдрийн хуралдаанаар хувьцаат компаниудын ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох асуудлыг хэлэлцэж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор хувьцаат компаниудын ногдол ашгийг зөвхөн “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аар зуучлуулан тарааж байхыг нээлттэй хувьцаат компаниудын удирдлагуудад даалгахын зэрэгцээ хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх үүргийг брокерийн компаниудад үүрэг болголоо.

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

- “Дархан Нэхий” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 1-р сарын 31-ний өдрийн №02/3 тоот тогтоолоор нэгж хувьцаандаа 210 төгрөг буюу нийт 232.1 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тараахаар болов.
- “Ард Кредит ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 1-р сарын 27-ны өдрийн хурлаар тус компанийн Гүйцэтгэх захирлаар Гэрэлтийн Тэлмэнг томилсон байна.
- “Дархан нэхий” ХК-аас хувьцааны арилжааны идэвхийг сайжруулах зорилгоор нэгж хувьцааг 1,000 хуваахаар төлөвлөжээ.
- “Лэндмн ББСБ” ХК 2019 оны цэвэр ашгийн 24.4%-ийг ногдол ашигт олгоно.



БУСАД МЭДЭЭ

Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллага /ФАТФ/-аас гаргасан Техникийн хэрэгжилтийн 40 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн системийг уг гэмт хэрэгт өртөх эрсдэлээс хамгаалах, гарал үүсэл нь тодорхойгүй, хууль бус үйл ажиллагаанаас олсон орлого, мөнгө угаах зорилготой этгээдийг санхүүгийн системд нэвтрүүлэхгүй байх шаардлагыг тодорхойлсон “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын төслийг боловсруулан Захиргааны ерөнхий хуулийн 62.1-д заасны дагуу санхүүгийн салбарт оролцогчид болон олон нийтээс санал авч, хэлэлцүүлж байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

- Гадаад худалдааны бараа эргэлт I сард өмнөх оноос 16.1 хувиар буурч, 932.3 сая ам.доллар хүрэв.
- Нүүрсний гол боомтуудын экспорт эрс буурлаа.
- Ипотекийн зээлийн санхүүжилт 2019 онд өмнөх оноос 80 орчим хувиар нэмэгджээ.
- 2020 онд хайгуулын лицензийн төлбөрийг 100 хувь орон нутагт хуваарилна.
- Шинэчилсэн хамгаалалтын элемент бүхий мөнгөн тэмдэгтүүдийг гүйлгээнд гаргана



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Монголбанк 50, 20,000 төгрөгийн дэвсгэртүүдийн нөөцийг дахин бүрдүүлэх шаардлагатай болсон ба эдгээр дэвсгэртүүдэд орчин үеийн технологи бүхий хамгаалалтын шинэ элементүүдийг оруулан шинэчлэн сайжруулж, гүйлгээнд гаргахаар боллоо.

Шинэчилсэн хамгаалалтын элементүүд нь иргэд энгийн нүдээр хараад хуурамч дэвсгэртээс төвөггүй ялгаж, таних боломжтой байх бөгөөд 3 хэмжээст, микро оптик, хөдөлгөөнт гадаргуутай тууз болон 3 хэмжээст өнгө нь хувирагч элемент, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор таних тэмдэг зэргийг дурдаж болно. Шинэ 20,000 төгрөгийн дэвсгэрт нь түүхэн болон үндэсний уламжлалт хэв маягийг хамгийн сүүлийн үеийн технологитой төгс хослуулснаараа онцлог юм.

Шинэчлэн сайжруулсан 50 болон 20,000 төгрөгийн мөнгөн дэвсгэртүүдийг 2-р сарын 10-наас эхлэн банкуудад гаргаж, банкууд харилцагчдадаа олгох замаар гүйлгээнд гаргана.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Шинэ төрлийн “коронавирус”-ийн нөлөөгөөр БНХАУ-ын талын татан авалт багасаж, Монголын нүүрсний экспорт огцом буураад байна. БНХАУ-ын сар шинийн баярын амралтын дараагаас Гашуунсухайт-Ганцмод боомтоор өдөрт 100 хүрэхгүй автомашин нүүрс гаргаж байгаа талаар тус боомтын удирдлага мэдээллээ. Хэвийн үед өдөрт 800-1,000 орчим автомашин нүүрс тээвэрлэж гардаг бол өнгөрсөн даваа гарагт хамгийн их буюу 111 автомашин нүүрс гаргажээ. БНХАУ-ын талын татан авалт эрс буурснаас гадна нэг автомашиныг ариутгахад 20 орчим минут зарцуулж байгаа зэргээс шалтгаалж нүүрсний машинуудыг нэвтрүүлэхэд хугацаа их орж байгаа гэдгийг боомтын удирдлага мэдээллээ.



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАВ

Олонулсад зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагуудаас Moody's, Standard & Poor's болон Fitch Ratings агентлагуудыг "Том 3" хэмээн нэрлэдэг ба эдгээр байгууллагуудын гаргасан урт хугацааны зээлжих зэрэглэлийг дараах хүснэгтийн дагуу тайлбарладаг байна. (Хүснэгт 1)

Монгол улсын хувьд зээлжих зэрэглэлийг олон улсын зэрэглэл тогтоогч эдгээр 3 агентлаг тодорхойлсон байдаг ба Standard & Poor's агентлагын хувьд 1999 оноос, Moody's болон Fitch Ratings агентлагууд 2005 оноос тус тус тогтоож эхэлжээ.

Moody's


Moody's агентлаг хамгийн сүүлд 2020 оны 01-р сарын 21-ний өдөр Монгол улсын зээлжих зэрэглэлийг "B3" хэвээр хадгалж, хэтийн төлөвийг "тогтвортой" гэж үзлээ. Монгол улсын төсвийн алдагдал болон өрийн хэмжээ нь ижил зээлжих зэрэглэл бүхий улс орнуудын голчтой ойролцоо байгаа нь Монгол улсын төсвийн эрсдэлийн эсрэг хамгаалалт болж байгаа ч зохицуулах байгууллагууд болон тэдгээрийн засаглал сул байгаа нь зээлжих зэрэглэлийг хязгаарлаж байна. Мөн Монгол улсын эдийн засгийг түүхий эдийн үнийн мөчлөгөөс бага хамааралтай болгох шинэчлэлүүд сул хийгдэж байгаа ба одоогоор макро эдийн засгийн бодлогод үүнтэй холбоотой шинэчлэлүүд тусгагдаагүй байна гэж мэдээлжээ. Moody's агентлагийн үзсэнээр БНХАУ сэргээгдэх эрчим хүчийг илүү сонгож байгаатай холбоотой түүхийн эдийн ханш буурч байгаа ч гангийн үйлдвэрлэлийн эрэлт тогтвортой байгаа тул Монгол улсын эдийн засгийн өсөлт өндөр байна

Хүснэгт 1. Том 3-ийн зээлжих зэрэглэлийн тайлбар

Moody's	Standard & Poor's	Fitch Ratings	Тайлбар
Aaa	AAA	AAA	Хамгийн сайн
Aa1	AA+	AA+	Өндөр үнэлгээтэй
Aa2	AA	AA	
Aa3	AA-	AA-	
A1	A+	A+	Дундажаас дээгүүр үнэлгээтэй
A2	A	A	
A3	A-	A-	
Baa1	BBB+	BBB+	Дундажаас доогуур үнэлгээтэй
Baa2	BBB	BBB	
Baa3	BBB-	BBB-	
Ba1	BB+	BB+	Хөрөнгө оруулалтын бус, спекуляци үнэлгээтэй
Ba2	BB	BB	
Ba3	BB-	BB-	
B1	B+	B+	Өндөр хэмжээний спекуляци үнэлгээтэй
B2	B	B	
B3	B-	B-	
Caa1	CCC+	CCC+	Эрсдэл өндөр
Caa2	CCC	CCC	
Caa3	CCC-	CCC-	
Ca	CC	CC	Маш өндөр хэмжээний спекуляци үнэлгээтэй
	C	C	Зээлээ төлөх чадамжгүй болно
C	RD	DDD	Зээлээ төлөх чадамжгүй болсон
/	D	DD	
/	D	D	

Зураг 1. Монгол улсын зээлжих зэрэглэл болон хэтийн төлөв (Moody's)

Ba3



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАВ (ҮРГЭЛЖЛЭЛ)

гэсэн хүлээлттэй байна. Түүнчлэн, Монгол улс богино хугацааны гадаад өр төлбөрөө төлөх хангалттай чадамжтай байгаа ба түүхий эдийн ханшийн савлагаанаас үүсэх эрсдэлийг бүтцийн өөрчлөлтөөр болон засаглалын сайжруулалтаар шийдэж чадвал зээлжих зэрэглэл нэмэгдэх боломжтой байгаа ч Монгол улсын хямд өртгөөр санхүүжилт босгох боломжууд хумигдаж байгаа нь зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлж байгааг онцолжээ.

Fitch Ratings


Fitch Ratings агентлагаас хамгийн сүүлд 2019 оны 7-р сарын 4-ний өдөр Монгол улсын урт хугацааны зээлжих зэрэглэлийн үнэлгээг "B" хэвээр үлдээж, хэтийн төлөвийг "тогтвортой" гэж үнэлсэн байна. Тус үнэлгээгээр Fitch Rating агентлагийн зүгээс Монгол улсын эдийн засаг эерэг хүлээлттэй байгаа ба сүүлийн жилүүдийн төсвийн үзүүлэлтүүд сайжирч байгаа ч эдийн засаг нь уул уурхайн салбараас хэт хамааралтай, гадаад хүчин зүйлсийн эрсдэлээс хамгаалах бололцоо сул ба улс төрийн тогтворгүй байдлаас хамаарч эдийн засгийн бодлого огцом өөрчлөгдөж, энэ нь цаашлаад эдийн засагт гэнэтийн шок учруулах магадлал ихтэй байгааг онцолжээ. Төсвийн үзүүлэлтүүд Fitch агентлагийн хүлээлтээс илүү сайжирсан ба гадаад валютын албан нөөцийн түвшин нь өнөөгийн Монгол Улсын гадаад төлбөр тооцооны дүнгээс ойролцоогоор 4.4 дахин их байгаа нь зээлжих зэрэглэл "BB" үнэлгээтэй улсуудын голчтой ойролцоо байна. Мөн төсвийн эрсдэлүүдийн эсрэг хамгаалалт сайжирч байгаа ч нийт гадаад өр ДНБ-ний 180%-тай тэнцэж байна. Түүнчлэн,

экспортолж буй түүхий эдийн ихэнх хэсгийг БНХАУ-руу экспортолж байгаатай холбоотойгоор Монгол улсын эдийн засаг гадаад хүчин зүйлсийн гэнэтийн шоконд эмзэг байгаа нь зээлжих зэрэглэлийг хязгаарлаж байна хэмээн мэдээлж байжээ.

Standard & Poor's

Standard & Poor's агентлагын хувьд 2019 оны 11-р сарын 28-ны өдөр Монгол улсын зээлжих зэрэглэлийг "B" хэвээр үлдээж, төлөвийг "тогтвортой" гэж үнэлжээ. Тус агентлагийн зүгээс хэдийгээр Монгол улсын төсвийн үзүүлэлтүүд болон эдийн засгийн өсөлтийн боломжууд сайжирч байгаа ч төрийн институцийн тогтворгүй байдал болон нийт гадаад өрийн хэмжээ их байгаатай холбоотойгоор Монгол улсын зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээжээ. Засгийн газраас эдийн засгийн үр ашигтай бодлогуудыг хэрэгжүүлж байгаа нь Монгол улсын макро эдийн засгийн хүлээлтийг нэмэгдүүлсэн байна. Энэ нь хэтийн төлөвт эерэгээр нөлөөлсөн ч Монгол улсын эдийн засгийн өсөлт түүхий эдийн зах зээлийн гэнэтийн ханшийн уналтаас хамааран уналтад орох эрсдэл байгаа нь төлөвийг "тогтвортой" хэвээр үлдээхэд нөлөөлжээ. Түүнчлэн Standard & Poor's агентлагийн хувьд Монгол улсын эдийн засаг уул уурхайн салбарын экспортын өсөлттэй холбоотойгоор 3 дахь жилдээ 5 хувиас дээш хэмжээгээр өсөх хүлээлттэй байгаа ч түүхий эдийн зах зээлийн гэнэтийн үнийн савлагаанд хэт эмзэг, улс төрийн эрсдэл их, эдийн засаг уналтад ороход гадаад өрийн дарамтад орох эрсдэл их байгааг онцолжээ.


Зураг 2. Монгол улсын зээлжих зэрэглэл болон хэтийн төлөв (Fitch Rating)



ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙГ ХЭВЭЭР ХАДГАЛАВ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зураг 3. Монгол улсын зээлжих зэрэглэл болон хэтийн төлөв (Standard & Poor's)



Монгол улсын зээлжих зэрэглэл болон хэтийн төлөв нь сүүлийн жилүүдэд буурч хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд багтаад байсан ч 2018 онд эдгээр агентлагууд Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг нэг шат ахиулсан байдаг билээ. Эдгээр агентлагууд сүүлд нийтэлсэн тайлангууддаа Монгол улсын эдийн засгийн боломж сайн байгаа болон төсвийн гүйцэтгэл эрс сайжирсан ч улс төрийн эрсдэл болон Монгол улсын эдийн засаг уул уурхайн салбараас хэт хамааралтай байгааг бүгд онцолжээ. Иймд, түүхий эдийн үнийн гэнэтийн савлагаанаас үүсэх Монгол улсын эдийн засгийн эмзэг байдлыг бүтцийн өөрчлөлтөөр дамжуулах бууруулах нь эдийн

засгийг гадаад хүчин зүйлсээс үүсэх гэнэтийн шокоос хамгаалахаас гадна зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөлөхөөр байгаа юм.

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.